



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУУЦАГААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/93/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn "Баянташаагийн эх аудит" ХХК-ний аудитор: Ч.Чимгээ Утас: 89915909 Цахим хаяг: bte.audit@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт	15
Залруулсан алдаа	16
Аудитын зөвлөмж	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал	16
6 Хавсралт. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18



БАЯНХОНГОР АЙМГИЙН БУУЦАГААН
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ГЭРЛЭЭ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 21/52

танай _____-ны № _____-т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус Цэцэрлэг нь Бууцагаан сумын Засаг дарга, Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газартай хамтарсан гэрээ байгуулан ажиллаж, сүүлийн хагас жилийн гэрээ 97,0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

2021 А4 ТООТ

• 005020148

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,400,463.83	70,971,383.83
33	АВЛАГА	00.00	17,098,700.00
335	Бусад авлага	00.00	17,098,700.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	17,098,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	83,400,463.83	53,872,683.83
354	Хангамжийн материал	83,400,463.83	53,872,683.83
35410	Бичиг хэргийн материал	614,600.00	614,600.00
35420	Аж ахуйн материал	47,170,323.28	25,032,869.28
35450	Барилгын засварын материал	4,160,000.00	00.00
35460	Хүнсний материал	2,027,826.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	29,427,714.55	28,225,214.55
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,190,003,447.40	1,163,410,798.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,190,003,447.40	1,163,410,798.22
392	Биет хөрөнгө	1,160,603,447.40	1,134,010,798.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,185,101,395.76	1,185,101,395.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,915,273.16	-79,225,796.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,085,634.25	36,404,134.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,085,634.25	-27,079,384.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,603,213.80	24,468,413.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,193,188.00	-9,665,264.03
39217	Ном	4,007,299.00	4,007,299.00
393	Биет бус хөрөнгө	29,400,000.00	29,400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	29,550,000.00	29,550,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-150,000.00	-150,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,273,403,911.23	1,234,382,182.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	44,106.00	192,607.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,106.00	192,607.00
413	Өглөг	44,106.00	192,607.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	44,106.00	164,607.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	28,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,273,359,805.23	1,234,189,575.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,273,359,805.23	1,234,189,575.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	118,876,104.00	118,876,104.00
51101	Өмч: - төрийн	118,876,104.00	118,876,104.00
512	Хуримтлагдсан үр дүн	935,986,914.83	896,816,684.65
51210	Өмнөх үеийн үр дүн	935,986,914.83	935,986,914.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-39,170,230.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	218,496,786.40	218,496,786.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,273,403,911.23	1,234,382,182.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	436,678,000.00	431,808,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	5,388,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	5,388,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	5,388,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	5,388,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	52,396,400.00	48,045,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	384,281,600.00	378,373,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,736,000.00	5,562,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,736,000.00	5,562,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,660,400.00	42,483,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,660,400.00	42,483,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	447,309,759.25	470,978,330.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	447,309,759.25	470,978,330.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,106,052.25	458,419,415.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,972,153.00	272,808,498.00
210101	Үндсэн цалин	242,776,110.00	272,808,498.00
210102	Нэмэгдэл	134,584.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	61,459.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,490,028.00	34,267,339.00
210201	Тэтгэврийн даатгал	21,838,763.00	23,545,750.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,451,147.00	2,704,642.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,940,573.00	2,170,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	433,436.00	523,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,826,109.00	5,323,519.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,660,400.00	36,931,323.52
210301	Гэрэл, цахилгаан	3,456,400.00	2,044,723.52
210302	Түлш, халаалт	39,204,000.00	34,303,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	583,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,653,498.00	27,700,942.00
210401	Бичиг хэрэг	326,800.00	439,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,140,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,836,078.00	1,815,000.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,140,620.00	23,706,242.00
2105	Нормативт зардал	60,606,980.00	31,491,064.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	464,850.00	114,500.00
210502	Хоол, хүнс	57,794,550.00	28,258,152.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,347,580.00	3,118,412.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,064,020.00	7,578,200.00
210604	Урсгал засвар	8,064,020.00	7,578,200.00
2107	Томилолт, зочны зардал	257,000.00	163,300.00
210702	Дотоод албан томилолт	257,000.00	163,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	412,500.00	340,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	162,500.00	90,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,989,473.25	47,138,749.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,896,300.00	3,362,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,093,173.25	43,776,349.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,203,707.00	12,558,914.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,904,200.00	5,737,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,736,000.00	5,562,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	168,200.00	174,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,552,276.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,552,276.48
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	299,507.00	2,269,538.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	299,507.00	2,269,538.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-10,631,759.25</u>	<u>-39,170,230.18</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-10,631,759.25</u>	<u>-39,170,230.18</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>436,678,000.00</u>	<u>426,419,600.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>436,678,000.00</u>	<u>426,419,600.00</u>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	384,281,600.00	378,373,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,736,000.00	5,562,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,736,000.00	5,562,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,660,400.00	42,483,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,660,400.00	42,483,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>436,678,000.00</u>	<u>426,419,600.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>436,678,000.00</u>	<u>426,419,600.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>430,474,293.00</u>	<u>413,860,685.52</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,083,800.00	272,563,682.00
210101	Үндсэн цалин	199,951,300.00	181,430,113.74
210102	Нэмэгдэл	22,121,484.00	52,892,169.00
210104	Урамшуулал	18,544,816.00	38,241,399.26

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210105	Гэрээт ажлын хөлс	3,466,200.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,416,665.00	34,391,654.00
210201	Тэтгэврийн даатгал	20,635,300.00	23,675,086.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,551,300.00	2,720,079.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,940,573.00	2,170,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	400,518.00	502,771.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,888,974.00	5,323,618.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,660,400.00	36,931,323.52
210301	Гэрэл, цахилгаан	3,456,400.00	2,044,723.52
210302	Түлш, халаалт	39,204,000.00	34,303,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	583,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,353,978.00	4,857,300.00
210401	Бичиг хэрэг	128,700.00	156,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,140,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,710,178.00	1,435,100.00
210404	Ном, хэвлэл	84,100.00	87,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	169,400.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,121,600.00	1,438,200.00
2105	Нормативт зардал	62,146,050.00	41,359,826.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78,500.00	2,565,200.00
210502	Хоол, хүнс	59,813,250.00	26,230,326.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,254,300.00	12,564,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,396,000.00	14,563,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	12,295,000.00
210602	Тавилга	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	29,396,000.00	2,268,200.00
2107	Томилолт, зочны зардал	257,000.00	163,300.00
210702	Дотоод албан томилолт	257,000.00	163,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	581,300.00	1,063,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	381,300.00	813,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,579,100.00	7,966,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,579,100.00	7,966,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,203,707.00	12,558,914.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,904,200.00	5,737,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,736,000.00	5,562,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	168,200.00	174,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,552,276.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,552,276.48
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	299,507.00	2,269,538.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	299,507.00	2,269,538.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	00.00	943,997,473.46	1,062,873,577.46
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,876,104.00	00.00	943,997,473.46	1,062,873,577.46
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,763,710.49	11,763,710.49
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	935,986,914.83	1,273,359,805.23
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	935,986,914.83	1,273,359,805.23
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	935,986,914.83	1,273,359,805.23
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-39,170,230.18	-39,170,230.18
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	896,816,684.65	1,234,189,575.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	425,314,500.00	414,035,585.52	(11,278,914.48)	97.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,314,500.00	414,035,585.52	(11,278,914.48)	97.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,139,600.00	413,860,685.52	(11,278,914.48)	97.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,878,300.00	272,563,682.00	(314,618.00)	99.88
210101	Үндсэн цалин	198,587,500.00	181,430,113.74	(17,157,386.26)	91.36
210102	Нэмэгдэл	36,049,400.00	52,892,169.00	16,842,769.00	146.72
210104	Урамшуулал	38,241,400.00	38,241,399.26	(0.74)	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,995,400.00	34,391,654.00	(1,603,746.00)	95.54
210201	Тэтгэврийн даатгал	25,144,800.00	23,675,086.00	(1,469,714.00)	94.15
210202	Тэтгэмжийн даатгал	2,712,700.00	2,720,079.00	7,379.00	100.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,170,100.00	2,170,100.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	542,600.00	502,771.00	(39,829.00)	92.66

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал -	5,425,200.00	5,323,618.00	(101,582.00)	98.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,940,700.00	36,931,323.52	(9,009,376.48)	80.39
210301	Гэрэл, цахилгаан	3,456,500.00	2,044,723.52	(1,411,776.48)	59.16
210302	Түлш, халаалт	41,484,200.00	34,303,500.00	(7,180,700.00)	82.69
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	583,100.00	(416,900.00)	58.31
2104	Хангамж, бараа материалын зардал	4,997,700.00	4,857,300.00	(140,400.00)	97.19
210401	Бичиг хэрэг	157,400.00	156,500.00	(900.00)	99.43
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,435,100.00	1,435,100.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	87,500.00	87,500.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	351,500.00	240,000.00	(111,500.00)	68.28
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,466,200.00	1,438,200.00	(28,000.00)	98.09
2105	Нормативт зардал	41,376,900.00	41,359,826.00	(17,074.00)	99.96
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,581,600.00	2,565,200.00	(16,400.00)	99.36
210502	Хоол, хүнс	26,231,000.00	26,230,326.00	(674.00)	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,564,300.00	12,564,300.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,564,200.00	14,563,200.00	(1,000.00)	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,296,000.00	12,295,000.00	(1,000.00)	99.99
210604	Урсгал засвар	2,268,200.00	2,268,200.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	163,300.00	163,300.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	163,300.00	163,300.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,256,500.00	1,063,900.00	(192,600.00)	84.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,006,500.00	813,900.00	(192,600.00)	80.86
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7966600.00	7966500.00	(100.00)	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,966,600.00	7,966,500.00	(100.00)	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	174900.00	174900.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	174,900.00	174,900.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	174,900.00	174,900.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	425,314,500.00	414,035,585.52	(11,278,914.48)	97.35
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	378,373,800.00	376,104,262.00	(2,269,538.00)	99.40
131007	Тусгай зориулалтын	378,373,800.00	376,104,262.00		99.40

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	шилжүүлгээс санхүүжих			(2,269,538.00)	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,940,700.00	37,931,323.52	(9,009,376.48)	80.81
132001	Орон нутгийн төсвөөс	46,940,700.00	37,931,323.52	(9,009,376.48)	80.81
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	-	1.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	-	1.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00	-	1.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	27.00	2.00	108.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	18.00	2.00	112.50
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	205.00	205.00	-	100.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	01.00	01.00	-	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	01.00	01.00	-	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	17.00	19.00	2.00	111.76
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	08.00	08.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,736,600.00	11,124,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,736,600.00	11,124,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,736,600.00	11,124,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,736,600.00	11,124,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,736,600.00	11,124,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,736,600.00	11,124,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,736,600.00	11,124,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,736,600.00	11,124,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Д.Гэрлээ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 27-ээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Баянташаагийн эх аудит” ХХК-ний аудитор Т.Хоролсүрэн, Ч.Чимгээ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Тус цэцэрлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Төрийн Аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 44 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бууцагаан сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хүүхэд болон багшийн хөгжлийг дэмжих, эрүүл, аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхэд хамгааллын талаарх бусад үндэсний бодлого, дүрэм, журам

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бууцагаан сумын Цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Бууцагаан сумын Цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 444628,5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8892,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 470978,3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9419,6 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн 1279531,2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 17183,7 мянган төгрөгөөр буюу 1,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,400.5	70,971.4	(12,429.1)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	17,098.7	17,098.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	83,400.5	53,872.7	(29,527.8)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,190,003.4	1,163,410.8	(26,592.6)
Үндсэн хөрөнгө	1,262,347.5	1,279,531.2	17,183.7
Хуримтлагдсан элэгдэл	(72,344.1)	(116,120.4)	(43,776.3)
Нийт хөрөнгө	1,273,403.9	1,234,382.2	(39,021.7)
Өр төлбөр	44.1	192.6	148.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,273,359.8	1,234,189.6	(39,170.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,273,403.9	1,234,382.2	(39,021.7)

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Тайлант онд эргэлтийн хөрөнгө 70971,4 мянган төгрөг болж 12429,1 мянган төгрөгөөр буурсан нь авлага 17098,7 мянган төгрөгөөр өсч, бараа материалын үлдэгдэл 29527,8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой.

Авлагын үлдэгдэл өссөн нь Дархан сүрэг хоршоонд зөөлөн эдлэл авах гэрээ хийн 8078,7 мянган төгрөгийг 2020 оны 12 сарын 25-нд нормын хувцас зөөлөн эдлэл авах зардлаас, НСН ХХК-иас камержуулалтын төхөөрөмж авахаар гэрээний дагуу 7500,0 мянган, гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ 1520,0 мянган төгрөгийг Тулга техник ХХК-д багаж, техник хэрэгсэл авах зардлаас 2020 оны 12 сарын 25-нд тус тус шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1279531,2 мянган төгрөг болж 17183,7 мянган төгрөгөөр өссөн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1234189,6 мянган төгрөг болж 39170,2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн хасагдсанаас шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 431808,1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4869,9 мянган төгрөгөөр буюу 1,1 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос 5388,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон тайлант онд тусламж санхүүжилтийн орлого 4350,6 мянган, орон нутгийн санхүүжилт 4176,8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Бараа үйлчилгээний нийт зардал 470978,3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 23668,6 мянган төгрөгөөр буюу 5,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 29836,4 мянган, хангамж бараа материалын зардал 21047,4 мянган төгрөгөөр өссөн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6729,1 мянган, норматив зардал 29115,9 мянган төгрөгөөр, тус тус буурсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 524461,6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 524461,6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нүүдлийн бүлэг ажиллуулах зардлыг 11959,0 мянган төгрөгөөр бууруулж 512502,6 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас таван удаа тодотгол хийж жилийн эцэст 425314.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 414035,6 мянган төгрөгийн төсөв баталснаас 376104,3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 37931,3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 378104,3 мянган, орон нутгийн төсвөөс 37931,3 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 414035,6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс 11278,9 мянган төгрөг дутуу зарцуулсан нь цалингийн болон нийгмийн даатгалын зардлыг 1918,3 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9009,4 мянган, хангамж бараа материалын зардлыг 140,4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсөвт зардлыг дутуу зарцуулсан нь сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрийн байр ашиглалтын үйлчилгээний зардал 6729.2 мянган, боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагааны зардал 4820,4 мянган төгрөгөөр хэмнэгдэж, нүүдлийн бүлэг ажиллуулах зардал 264,7 мянган төгрөгөөр илүү зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардлын гүйцэтгэл /мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71801	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	425314,5	414035,6	(11278,9)	97,3
1.1	81834	Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагааны зардал	304382,5	300845,5	(3537,0)	98,8
1.2	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	47076.4	47076.4	0	100.0
1.3	81832	Нүүдлийн бүлэг	509,0	509.0	(0)	100,0
1.4	80109	Байр ашиглалтын үйлчилгээ	46940,7	39199,5	(7741,2)	83,5
1.5	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	26231.0	26230.3	(0.7)	100.0
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	174,9	174.9	0,0	100,0

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны төсвийн хэлбэлзлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны 5 жилийн тэтгэмжийн санхүүжилт 11124,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зориулалтын дагуу багш нарт олгосон байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд байршуулж, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, батлагдсан төсөв, хөрөнгө зарцуулах шийдвэр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг 4 төрлийн мэдээллийг байршуулснаас хойш дахин засварласнаас хугацаа хоцорсон төлөвт орж, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Хүснэгт 3. www.shilendans.gov.mn цахим хуудсан дахь мэдээлэл

Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	7	5		2
2	Хагас жил	4	8	8		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	94	4	
	Нийт	27	151	145	4	2

Эх сурвалж: www.shilendans.gov.mn цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 223,4 мянган төгрөгийн акт тавигдаж бүрэн биелэгдсэн.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1520,0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой залруулсан алдаа гараагүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Тухайн санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага өгөгдөөгүй.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1520,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль, эрх зүйн орчинтой холбоотой асуудал

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ 1520.0 мянган төгрөгийг Тулга техник ХХК-д 2020 оны 12 сарын 25-нд шилжүүлж авлага үүсгээд, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг зөрчсөн.

1.2. Эрсдэл: Үргүй зардал гарч, өр авлага нэмэгдэх

1.3 Өгсөн зөвлөмж: Тулга техник ХХКомпаниас гал тогооны дагалдах хэрэгслийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах" заалтыг мөрдөж өр авлага үүсгэхгүй ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Дархан сүрэг хоршоонд зөөлөн эдлэл авах гэрээ хийн 8078,7 мянган, НСН ХХК-иас камержуулалтын төхөөрөмж авахаар гэрээний дагуу 7500,0 мянган, Тулга техник ХХК -иас гал тогооны дагалдах хэрэгсэл худалдан авахаар 1520,0 мянган төгрөгийг 2020 оны 12 сарын 25-нд тус тус шилжүүлснээр тухайн оны санхүүгийн тайлангийн авлага өмнөх оноос 17098,7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д " төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Үргүй зардал гарч, өр авлага нэмэгдэх

2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах" заалтыг мөрдөж өр авлага үүсгэхгүй ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.Тухайн байгууллага, салбартай хууль, эрх зүйн орчинтой холбоотой асуудал

3.1Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, батлагдсан төсөв, хөрөнгө зарцуулах шийдвэр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг 4 төрлийн мэдээллийг байршуулснаас хойш дахин засварласнаас хугацаа хоцорсон төлөвтэй болж, хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

3.2 Эрсдэл: Мэдээллийн ил тод байдал алдагдах

3.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Мэдээлэл хоцорсон нь Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албын шилэн дансны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дагуу байршуулсан мэдээлэлд засвар хийсэн тохиолдолд хоцорсон төлөвт шилждэгээс шалтгаалсан гэж тайлбар ирүүлсэн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тухайн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР

Ч.Чимгээ
Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР



А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.25

Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит		Аудитын код:	
2021				БНА-2021/93/СТА-ТШЗ	
Шалгагдсан байгууллагын нэр:		Бууцагаан сумын цэцэрлэг		Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ 1520.0 мянган төгрөгийг Тулга техник ХХК-д 2020 оны 12 сарын 25-нд шилжүүлж авлага үүсгээд авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1520,0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч нягтлан бодогч	Д.Гэрлээ Д.Мөнхтуяа
2	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, батлагдсан төсөв, хөрөнгө зарцуулах шийдвэр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг 4 төрлийн мэдээллийг байршуулснаас хойш дахин засварласнаас хугацаа хоцорсон төлөвтэй болж, хугацаа хоцроож мэдээлсэн	0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч нягтлан бодогч	Д.Гэрлээ Д.Мөнхтуяа
3	Тухайн оны санхүүгийн тайлангийн авлага өмнөх оноос 17098,7 мянган төгрөгийн авлага, өглөг 148,5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д " төсвийг зохистой удирдаж, ер төлбөр үүсгэхгүй байх" заалтыг зөрчсөн байна	15727,2	Зөвлөмж өгөх	Эрхлэгч нягтлан бодогч	Д.Гэрлээ Д.Мөнхтуяа
ДҮН		17247,2			

---ooOoo--